



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 20 өдөр

Дугаар А/59

Сүхбаатар сум

Цагааннуур сумын төрийн өмчийн 2 дугаар  
цэцэрлэгт тусгай зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5."а", "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4, Боловсролын тухай хуулийн 2С дугаар зүйлийн 20.1, 23 дугаар зүйлийн 23.1, 30 дугаар зүйлийн 30.1.6, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2010 оны 353 дугаар тушаалаар батлагдсан "Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавигдах шаардлага"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Цагааннуур сумын "Хуурч" 2 дугаар багт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 150 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэг 2019 онд шинээр ашиглалтад орсонтой холбогдуулан тус суманд төрийн өмчийн 2 дугаар цэцэрлэгийг шинээр байгуулж, сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 3 жилийн хугацаатай олгосугай.

2.Цагааннуур сумын төрийн өмчийн 2 дугаар цэцэрлэгийг улсын бүртгэлд бүртгэн гэрчилгээ олгохыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга /Б.Саранчимэг/-д үүрэг болгосугай.

3.Цагааннуур сумын төрийн өмчийн 2 дугаар цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Энхбат/, Боловсрол, соёл урлагийн газрын дарга /Ч.Жаргалсайхан/, Цагааннуур сумын Засаг дарга /Н.Зоригоо/ нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ш.ОРГИЛ



C:\users\albanbichig2020\zahiramjA4.cocx

430801165